

Төрийн албаны зөвлөлийн  
2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн  
60 дугаар тогтоолын 02 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хууль

Дагаж мөрдөх огноо:

2022 оны 01 дүгээр сарын 01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Гаалийн ерөнхий газар

Хорио цээрийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч

Дэс түшмэл, ТТ-4

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

14193 Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Их тойруу 81-1

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Албан ажлын онцгой нөхцөлд хамаарна

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд эрсдэлийн удирдлагад сууриссан хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлж, мэргэжлийн арга зүйн удирдлагаар ханган, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

**Албан тушаалын зорилт:**

- Улсын хилээр нэвтрүүлэх эрүүл ахуй, халдварт хамгаалал, чанар, стандарт, тохирлын хяналтад хамрагдах зорчигч, бараа, тээврийн хэрэгсэлд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- Хорио цээр, эрүүл ахуй, халдварт хамгаалал, чанар, стандарт, тохирлын хяналтад хамрагдах бараа, бүтээгдэхүүнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохих, хууль тогтоомжийн журмын дагуу хэрэгжүүлэх;
- Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх, хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах- Т, Гүйцэтгэх - Г Хянах- Х Шийдвэрлэх- Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Хүний олон улсын хөл хориот өвчин болон мал амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс хил дамжин тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариуг арга авч хэрэгжүүлэхэд бодлогын зөвлөгөө өгөх, энэ чиглэлээр холбогдох дүрэм, журам, заавар боловсруулж, батлуулах;	Хүний олон улсын хөл хориот өвчин, мал амьтны халдварт өвчин, ургамлын хорио цээрийн зүйлс хил дамжин тархахаас урьдчилан сэргийлсэн байна.	Г, Ш
	2. Хорио цээрийн хяналтад хамрагдах барааны эрсдэлийг тооцох шалгуурыг боловсруулж, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох;	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болсон байна	Г, Т,
	3. Бодис, бараа, бүтээгдэхүүнд хорио цээр, эрүүл ахуй, халдварт хамгаалал, чанар, стандарт, тохирлын эрсдэлд суурилсан байнгын хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулах;	Эрсдэлийг зөв тодорхойлж, бууруулсан байна.	Г, Т
	4. Хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй барааг тохирлын баталгаатайгаар улсын хилээр нэвтрүүлэх, тэдгээрт хяналт шалгалт хийж ажлыг зохион байгуулах, удирдамж, чиглэлээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих;	Гэрээ, конвенц, хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт хангагдсан байна.	Т, Ш
	5. Гадаад орны эрүүл ахуй, мал эмнэлэг, ургамлын хорио цээр,	Эрх зүйн орчин бүрдсэн байна.	Г, Ш



	чанар стандартын хяналтын байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах;		
	6. Монгол Улсад импортлох мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд эрсдлийн задлан шинжилгээ хийж импортын болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл олгох үйл ажиллагааг баталгаажуулах;	Холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байна.	Ш
	7. Монгол Улсаас экспортлох мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд олгох экспортын гэрчилгээг баталгаажуулах;	Холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрт нийцсэн байна.	Ш
	8. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын чиглэлээр улсын байцаагчдыг мэргэжлийн удирдлагаар хангаж, бусад нэгж, холбогдох газруудтай ажлын уялдаа холбоог хангах;	Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан байдал үр дүн	Г, Т, Ш
	9. Мал амьтан, ургамлын гаралтай түүхий эд, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлоход экспортлогч улсын үйлдвэр, аж ахуйн нэгжид эрсдэлийн үнэлгээг хийхэд дэмжлэг үзүүлэх.	Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын шаардлага хангагдана	Г, Ш
2 дугаар зорилтын хүрээнд	1. Хуулиар харьяалуулсан зөрчлийн хэргийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу, тогтоосон хугацаанд явуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	2. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг ирүүлсэн, эсхүл зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авах, байгууллагын болон прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, хянан шийдвэрлэх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл гомдлыг хянан үзэж, шийдвэрлэхэд чиглэлийн гаалийн улсын байцаагчдад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г, Т



3 дугаар зорилтын хүрээнд	1. Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож, төлөвлөгөөний төслийг боловсруулан, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна	X, Г
	2. Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил үүргийн хуваарийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;	Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд ажил үүрэг давхцахгүй, орхигдохгүй байхаар төлөвлөгдсөн байна	X, Г
	3. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	X, Т
	4. Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах;	Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна	Г, Х
	5. Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах, архивын нэгж бүрдүүлэх ажилд хяналт тавих;	Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна	X
	6. Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой програм хангамжийг боловсронгуй болгох санал өгөх ажлыг зохион байгуулах;	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн	Г
	7. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох, хамт олныг хамруулах.	Хамт олныг хамруулан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн	X, Г

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
-----------	---



Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл ахуй, тархвар судлал (102101),</li> <li>- нийгмийн эрүүл мэнд (098801),</li> <li>- мал эмнэлэг (084),</li> <li>- хөдөө аж ахуй (0811-0812, 0831).</li> </ul>
Мэргэшил	Төрийн албандаа мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажиллаж бол давуу тал болно.
	<p>Дүн шинжилгээ хийх</p> <ul style="list-style-type: none"> <li>- мэдээллийн алдаатай болон дутуу, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- улсын хилээр нэвтрүүлэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараанд эрсдэлийн удирдлагад суурилсан хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх ажлыг боловсронгуй болгох асуудлаар бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;</li> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, харьцуулсан судалгаа хийх;</li> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж, боловсруулж, дүгнэх;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх;</li> <li>- тулгамдаж буй асуудалд шийдэл олох, түүний эерэг, серөг үр дагаврын талаар дүн шинжилгээ хийх;</li> <li>- бусад.</li> </ul>
Ур чадвар	<p>Асуудал шийдвэрлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>- сэтгэн бodoх, анализ хийх, хөрвөх чадвартай байх;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- албан тушаалын чиг үүргийн хүрээнд гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;</li> <li>- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг оновчтой зохион байгуулах;</li> <li>- бусад.</li> </ul> <p>Багаар ажиллах</p> <ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх.</li> </ul>



	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;</li> <li>- мэдээллийн технологийн хэрэглээний мэдлэгтэй байх;</li> <li>- албан хаагчдад ажлын байран дээр тасралтгүй сурч хөгжих боломжийг бүрдүүлэх;</li> <li>- төрийн албан хаагчийн болон гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээ, үйлчилгээний стандарт, сахилгын тусгай дүрмийг чанд сахин ажиллах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;</li> <li>- монгол хэл бичгийн мэдлэгийн төвшин нь албан ажлын шаардлагыг хангасан;</li> <li>- өөрийн мэдлэг, чадвар, өөрт байгаа мэдээллийг баг, хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах;</li> <li>- багийн амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах.</li> <li>- харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглан, мэдээллийг хүргэх, түгээх.</li> </ul>
--	-------	--

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Хорио цээрийн хэлтсийн дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>  Гаалийн улсын байцаагч-10  Нийт: 10	<u>Бусад харилцах субъект:</u>  -Төрийн байгууллагын холбогдох ажилтан; -Гаалийн харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээд; -Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар хорооны дарга, албаны дарга, салбарын эрхлэгч, гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч, бусад ажилтан.
---	--

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:</u>  ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  .....И.ТАМИРАА (Гарын үсэг) (Өцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)  2023 оны 9 сарын 11-ны өдөр	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>  Байгууллагын нэр:  ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 23 0309 Дугаар: 260
---	--

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:



Байгууллагын нэр:

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: .....

Дугаар: .....

(тамга/тэмдэг)

ДАРГА..... Р.ОТГОНЖАРГАЛ

(Гарын усэг) (Эцэг/эх-/ийн нэр, өөрийн нэр)

2023 оны 07 дугаар сарын 16 -ны өдөр

